

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн
хэмжээг нэмэгдүүлж, тогтоох тухай

ҮНДЭСЛЭЛ: Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт үндэслэн дор дурдсан хэлбэрээр өөрчилж болно гэснийг;

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.1 дэх заалт Нэгж хувьцааны үнийг өсгөх гэснийг;

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг Дараах асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ гэснийг;

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал гэснийг

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2024 оны 8 сарын 29-ний өдрийн Тооллогын комиссын 24/05 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцааны нэг бүрийн нэрлэсэн үнийг 10 (арав) төгрөг байсанг 13.8 (арван гурав төгрөг найман мөнгө) төгрөг болгон нэмэгдүүлсүгэй.
2. Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэг бүр нь 10 (арав) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 364,000,000 /гурван зуун жаран дөрвөн сая/ хувьцаанаас бүрдэх 3,640,000,000 (гурван тэрбум зургаан зуун дөчин сая) төгрөг байсанг Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэг бүр нь 13.8 (арван гурав төгрөг найман мөнгө) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 364,000,000 /гурван зуун жаран дөрвөн сая/ хувьцаанаас бүрдэх 5,023,200,000 (таван тэрбум хорин гурван сая хоёр зуун мянга) төгрөг болгон нэмэгдүүлсүгэй.
3. Тогтоол батлагдсантай холбогдуулан 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын бүртгэлийн өдрөөр тооцон, Компанийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль болон зохицуулагч байгууллагаас баталсан журамд нийцүүлэн хуримтлагдсан ашгаас холбогдох татварыг суутган хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-т үүрэг болгосугай.
4. Компанийн дүрэмд энэхүү шийдвэрийн 1, 2 дахь хэсэгт заасан агуулгаар өөрчлөлт оруулж, компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулахыг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-г даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНЗОРИГ